

**ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ХУУЛИЙН ХЭЛТСИЙН САЛБАРЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН НЭГДСЭН ЗОХИЦУУЛАЛТ  
 ХАРИУЦСАН ШИНЖЭЭЧ ШИЖЭЭГИЙН МӨНГӨНЦЭЦЭГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН**

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
<b>Зорилт 1. Салбарын хэмжээнд мөрдөгдөж байгаа хууль тогтоомжуудын уялдаа холбоог сайжруулах, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах, албан хаагчдад хууль эрх зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагаа</b>							
1.	Арга хэмжээ 1.1. Яамны албан хаагчдад хууль, эрх зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.	Хууль, эрх зүйн зөвлөгөө өгсөн тоо	100	Сайд, Дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга, аппаратын ажилтнуудад хууль, эрх зүйн зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлсэн байна.	Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэрийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль, Онц байдлын тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай, Засгийн газрын зарим тогтоолууд, тушаал шийдвэрийн боловсруулалтын талаар тухай бүр давхардсан тоогоор 120 гаруй албан хаагчдад хууль, эрх зүйн зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлсэн байна.	01 12	
2.	Арга хэмжээ 1.2. Эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн	УИХ-д өргөн барьсан хууль	40%	Хуулийн төслийн үзэл баримтлалыг батлуулсан байна.	Эрүүл мэндийн сайд, Хууль зүй, Дотоод хэргийн сайдаар Эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн	01	

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	
	найруулгын төслийг боловсруулах ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар ажиллана.			үзэл баримтлалыг энэ оны 04 дүгээр сарын 30-ны өдөр батлуулсан.	12		
			Хуулийн төслийг боловсруулна.	Хуулийн төслийг боловсруулж, яамны албан ёсны вэб сайтад байршуулж, санал авсан.			
			Хуулийн төслийг Яамны удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.	-			
			Хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.	-			
<b>Зорилт 2. Хууль тогтоомжийн төсөлд санал өгөх, захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийн хяналт, бүртгэл, мэдээний сангийн үйл ажиллагаа</b>							
1.	Арга хэмжээ 2.1. Яамнаас боловсруулж байгаа хууль, тогтоомжийн төслийг хянаж санал өгнө	Хянаж санал өгсөн шийдвэрийн тоо	7	Эрүүл мэндийн яамнаас боловсруулж буй хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн төслүүдийг боловсруулахад эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг, санал өгсөн байна.	Эрүүл мэндийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, хадгалах, аюулгүй байдлыг хангах журмын төсөл, Засгийн газрын 2024 оны 100 дугаар тогтоолоор батлагдсан. Олон улсын чанарын шаардлага хангасан хүний эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, вакциныг гадаад улсын үйлдвэрлэгчээс, эсхүл олон улсын байгууллагаас шууд болон дамжуулан худалдан авах журам"-ын төсөл, Засгийн газрын 2024 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан.	01 12	

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
					Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг төвлөрүүлэн зарцуулах, хяналт тавих журмын төсөл, Засгийн газрын 2024 оны 78 дугаар тогтоолоор батлагдсан. Эмч нарын их хурлыг зохион байгуулах тухай Засгийн газрын тогтоолын төсөл, Засгийн газрын 2024 оны 261 дүгээр тогтоолоор батлагдсан. Дээрх тогтоолоор батлагдсан тогтоолуудын төслүүдийг боловсруулахад эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг, санал өгснөөр Засгийн газрын тогтоолууд батлагдсан. Мөн Эм, эмнэлгийн хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэх хилийн боомтыг тогтоох тухай Засгийн газрын 2011 оны 73 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тогтоолын төслийг хянаж, эрх зүйн дэмжлэг, санал өгсөн.		
2.	Арга хэмжээ 2.2. Бусад яам, холбогдох газруудаас ирсэн хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн төсөлд дангаар буюу холбогдох газар, хэлтэстэй хамтарч санал өгнө.	Санал боловсруулсан хууль тогтоомжийн тоо	238	Хууль тогтоомжийн төслийг судалж санал боловсруулж хүргүүлсэн байна.	Бусад яам, холбогдох газруудаас ирсэн 176 хууль тогтоомжийн төслийг судалж санал боловсруулж, албажуулан хүргүүлсэн байна.	01 12	
3.	Арга хэмжээ 2.3.	Улсын бүртгэлд бүртгэгдсэн	8	Хууль, Улсын Их Хурлын тогтоол,	Захиргааны хэм хэмжээ тогтоосон нийт 8 шийдвэрийн боловсруулалтанд зөвлөгөө,	01 12	

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)		
	1	2	3	4	5	6	7
	Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн боловсруулалтанд зөвлөгөө, санал өгөх, улсын бүртгэлд бүртгүүлнэ.	захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн тоо		Засгийн газрын тогтоол шийдвэрт нийцсэн байх ба ХЗДХЯ-ны улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн байна.	санал өгч, улсын бүртгэлд бүртгүүлсэн. Үүнд: Эрүүл мэндийн сайдын 2024 оны Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдваргүйжүүлэх бодисыг улсын бүртгэлд бүртгэх журмыг шинэчлэн батлах тухай А/74, Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2024 оны Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг магадлах, хөдөлмөр зохицуулалт хийхэд баримтлах өвчний зааврыг батлах тухай А/293, А/133, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан Жагсаалт батлах тухай А/96, А/104, А/81 дүгээр тушаал, Эрүүл мэндийн сайд, Хууль зүй, Дотоод хэргийн сайд, Улсын Ерөнхий прокурорын хамтарсан 2024 оны "Хүний эрүүл мэндэд учирсан хохирлын зэрэг тогтоох журам" А/225/А153/А/86 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайд, Хууль зүй, Дотоод хэргийн сайд, Улсын Ерөнхий прокурорын хамтарсан 2024 оны "Шүүх эмнэлгийн шинжилгээ хийх журам" А/259/А173/А/94 дүгээр тушаал,		

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)			
	1	2	3	4	5		6	7
					<p>Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавих хяналтын журам А/178, А/238, А/173 дугаар тушаал,</p> <p>Цусны байнгын болон амьд донорт эмнэлгийн тусламж, үйлчилгээг хөнгөлөлттэй үзүүлэх, жилд нэг удаа эрүүл мэндийн үзлэгт үнэ төлбөргүй хамруулах журам А/207 дугаар тушаалыг улсын бүртгэлд бүртгүүлсэн.</p>			
<b>Зорилт 3. Эрх зүйн маргаанд Эрүүл мэндийн яамыг төлөөлөн оролцох үйл ажиллагаа</b>								
	Арга хэмжээ №3.1. Эрх зүйн маргаанд ЭМЯ-ыг төлөөлөн оролцох	Шийдвэрлэгдсэн шүүх хуралдааны тоо	7	Итгэмжлэлийн дагуу нэхэмжлэлийг гардаж авах, хариу тайлбар, нотлох баримт гаргаж өгч, Эрх зүйн аливаа маргааныг хуулийн дагуу шийдвэрлүүлсэн байна.	<p>Эрүүл мэндийн сайдын итгэмжлэлийн дагуу шүүхийн шатанд дараах 5 хэрэг маргаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдон нэхэмжлэлийг гардаж авч, хариу тайлбар нотлох баримтуудыг гаргаж өгсөн.</p> <p>-С.Мягмардоржийн -Д.Түвшинзул -Дорнод аймгийн ҮЭХ -Эйч Ар Ви Констракшн -Санчир-Ундрах ХХК -Иргэн Л.Дэлгэрзулын нэхэмжлэлтэй Эрүүл мэндийн яаманд холбогдох арбитрын ажиллагаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдон ажиллаа.</p>		01 12	

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	
					<p>- Дорнод аймгийн Эмнэлгийн ажилтны үйлдвэрчний эвлэлийн нэгдсэн хорооны нэхэмжлэлтэй Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн А/531/136 дугаар “Журам батлах тухай” тушаалын хавсралтын 1.2 дахь заалтыг хүчингүйд тооцуулах шаардлага бүхий нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлүүлсэн.</p> <p>- Эйч ар ви констракшн ХХК-ийн бараа материалын үнийн өсөлтийн зөрүү төлбөрт 80,280,384 төгрөгийг гаргуулах нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлүүлсэн.</p> <p>Иргэн Л.Дэлгэрзулын “2022 оны 9 дүгээр сарын 5-ны өдрийн MN-MOH-313589-CS-INDV тоот гэрээг хугацаагүйгээр сунгагдсанд тооцуулах, ажилгүй байсан хугацааны 50,000,000 төгрөгийг хариуцагчаас гаргуулах нэхэмжлэлийн шаардлагын гэрээг хугацаагүйгээр сунгагдсанд тооцуулах, шаардлагыг хэрэгсэхгүй болгуулж, 18.000.000 сая төгрөг хариуцагчаас гаргуулахаар шийдвэрлүүлсэн.</p>		

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
					<p>-Д.Түвшинзулын нэхэмжлэлтэй Эрүүл мэндийн сайдын 2023 оны 03 дугаар марын 16-ны өдрийн Б/30 тоот тушаалыг хүчингүй болгож, Өмнөговь аймаг дахь Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн Ерөнхий захирлын албан тушаалд эгүүлэн томилуулах, цалингий зөрүү гаргуулах, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалыг нөхөн төлүүлж, бичилт хийлгүүлэх тухай шаардлага бүхий нэхэмжлэлтэй шүүх хуралдаан нэхэмжлэгчийн хүсэлтээр хойшлогдсон. Шүүх хуралдаан зарлагдаагүй байна.</p> <p>-Иргэн С.Мягмардоржийн ЭМЯ-наас 5,200,000 төгрөг гаргуулах тухай нэхэмжлэл бүхий хэргийн шүүх хуралдаан зарлагдаагүй байна.</p> <p>- Санчир-Ундрах ХХК-ийн 2019 оны 03 дугаар сарын 04-ны өдрийн 003/191258 дугаартай эм, эмнэлгийн хэрэгслийн импортын лицензийг, 2019 оны 06 сарын 20-ны өдрийн 003/19/3989 дугаартай эм, эмнэлгийн хэрэгслийн импортын лицензийн 1 дэх хэсэг, 2019 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 003/19/6443 дугаартай эм, эмнэлгийн хэрэгслийн импортын лицензийг илт</p>		

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			3	4	5	6	7
					хууль бус болохыг тогтоож өгөхийг хүссэн нэхэмжлэл бүхий шүүх хуралдаан энэ оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 16.30 минутаас зарлагдаад байна.		
<b>Зорилт 4. Нууц хамгаалах ажилтны чиг үүргийн хэрэгжилт</b>							
	Арга хэмжээ №4.1. Нууц хамгаалах ажилтны чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.	Хариутай нууц бичгийн шийдвэрлэлтийн хувь	100%	Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомж хэрэгжсэн байна.	Нууцын журмаар ирсэн, явсан албан бичгийн бүртгэлийг хөтөлж, холбогдох албан тушаалтанд танилцуулах, бүртгэлийн дугаар олгох, холбогдох байгууллагад хүргэж өгөх ажлыг хийж гүйцэтгэсэн. Ирсэн нууц, маш нууц албан бичгүүдийн шийдвэрлэлтийн хугацаанд хяналт тавьж ажилласан ба 100 % шийдвэрлэгдэж хариу өгөгдсөн. Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах хүрээнд Эрүүл мэндийн яамны 2023 онд хийсэн ажлын тайланг Тагнуулын Ерөнхий газарт нууцын журмаар албан бичгээр хүргүүлсэн. Нууц баримт бичигтэй танилцах эрх бүхий Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газрын дарга, Нийтийн эрүүл мэндийн газрын дарга, Төрийн захиргааны удирдлагын газрын даргаар ажиллаж байсан албан хаагчдын шилуилт хөдөлгөөнийг ТЕГ-рт	01 12	

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин: (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
					<p>энэ оны 11 дүгээр сарын 04-ны өдрийн 2/4491 дүгээр албан бичгээр хүргүүлсэн. Төрийн болон албаны нууцын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Эх,нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв-II, ХСҮТ, Герентологийн үндэсний төв, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд "Хууль хэрэгжүүлэх тухай" 11 сарын 05-ны өдрийн 2/4529 дүгээр албан бичгийг хүргүүлэв.</p> <p>Дээрх үйл ажиллагаануудыг хэрэгжүүлснээр төрийн болон албаны нууцыг хамгаалах хууль тогтоомжийн биелэлтийг хангах, нууц албан хэрэг хөтлөлтийг зохион байгуулж хэрэгжүүлсэн нь Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомж хэрэгжиж байна.</p>		
	Арга хэмжээ №4.2. Төрийн нууцтай танилцах албан хаагчдыг аюулгүй байдлын шалгалтад хамруулна.	Төрийн болон албаны нууцтай танилцах албан хаагчдын холбогдох материалыг бүрдүүлж, албан бичиг төлөвлөгдөж, албажсан байна.	7	ТЕГ-т холбогдох албан тушаалтнуудын материал хүргэгдсэн байна.	ТЕГ-т Төрийн болон албаны нууцтай танилцах эрх бүхий 1 албан тушаалтны материалыг цахимаар, аюулгүй байдлын шалгалтад хамруулах хүсэлтийг албан бичгээр хүргүүлж, аюулгүй байдлын шалгалтад хамруулж, нууц задруулахгүй баталгааг гаргуулж авсан. ТЕГ-ын аюулгүй байдлын шалгалтад хамруулсанаар	01 12	

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	
					Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомж болон Эрүүл мэндийн сайдын 2021 оны "Жагсаалт батлах тухай" А/712, 2023 оны А/74 дүгээр тушаал хэрэгжих нөхцөл боломж бий болсон.		
	Арга хэмжээ №4.3. 2023 оны нууцын журмаар ирсэн, явсан албан бичгийн архивын нэгж үүсгэн, архивлана.	Шинээр бүрдүүлсэн архивийн нэгж	100%	Холбогдох хууль журмын дагуу архивласан байна.	Эрүүл мэндийн яаманд нууцын журмаар ирсэн, явсан 2023 оны албан бичгүүдийг архивын нэгж болгон архивлав. Ингэснээр төрийн болон албаны нууц үрэгдэхээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой юм.	02	
<b>Зорилт 5. "Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах"</b>							
	Арга хэмжээ 5.1. Өөрт хувиарлагдсан өргөдөл, гомдлыг шийдвэрлэнэ.	Хугацаанд нь шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын тоо	-	Өргөдөл, гомдлыг судалж, шийдвэрлэсэн байна	Иргэн Өлзийбаярын шүүхийн шийдвэрийн дагуу 36 хүртэл сарын тэтгэмж олгохыг хүссэн өргөдлийг судлаж, шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх боломжийг судалж байгаа талаар хариуг энэ оны 3 сарын 18-ны өдрийн 2/73-ө дугаар бүхий албан бичгээр хариуг хүргүүлж, тус яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газарт дотоод меморандумыг хүргүүлсэн.  Г.Отгончимэгийн ажлаас үндэслэлгүй халагдсан талаарх өргөдлийг судлаж, Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу	01 12	

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	
					<p>хөдөлмөрийн маргаан таслах комисст хандахыг зөвлөж энэ оны 3 дугаар сарын 07-ны өдрийн 2/63-ө дугаар бүхий албан бичгээр хариуг хүргүүлсэн.</p> <p>Иргэн Л.Бат-Эрдэний урьдчилан шийдвэрлүүлэх журмаар гомдол гаргах тухай өргөдлийг судлаж энэ оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 2/2618 дугаар бүхий албан бичгээр хариуг хүргүүлсэн.</p>		
	Арга хэмжээ 5.2. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, хэм хэмжээг мөрдөнө.	Ёс зүйн зөрчлийн тоо	-	Ёс зүйн зөрчил гаргаагүй байна	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг уншиж, судалсан ба Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан Төрийн албан хаагчийн ёс зүйн талаарх сургалтуудад оролцож, ёс зүйн зөрчилгүй ажилласан.	01 12	
	Хөрөнгө орлогын мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт гаргана.	Хүргүүлсэн ХОМ-ийн тоо	100%	Хугацаанд нь гаргасан байна.	2023 оны Хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргасан.	01 02	
	Сайд, Дэд сайд, ТНБД, газрын даргаас өгсөн хуульд нийцсэн шуурхай үүрэг даалгаврыг цаг	Нэмэлтээр өгсөн шуурхай үүрэг даалгаварын хугацаанд нь гүйцэтгэсэн тоо		Нэмэлтээр өгсөн үүрэг даалгаварыг хугацаанд нь гүйцэтгэсэн байна.	Эрүүл мэндийн сайдын баталсан удирдамжийн дагуу Баянхонгор аймгийн нэгдсэн эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөлд арга зүйн дэмжлэг үзүүлж энэ оны 01 дүгээр сарын 28-30-ны өдрүүдэд ажиллав.	01 12	

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
	хугацаанд нь гүйцэтгэх				<p>Төрийн нарийн бичгийн даргын баталсан удирдамжийн дагуу Өмнөговь аймгийн БОЭТ-д төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг энэ оны 03 дугаар сарын 19-ний өдрөөс 23-ны өдрийн дуустал ажиллаж, Эрүүл мэндийн сайдын тушаалын хэрэгжилтийг хангаж тус төвийн даргын ажлыг хүлээлцүүлсэн.</p> <p>Төрийн нарийн бичгийн даргын баталсан удирдамжийн дагуу энэ оны 04 дүгээр сарын 09-ны өдрөөс 12-ны өдрийг хүртэл Дундговь аймгийн нэгдсэн эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөлийн хамт олны төлөөллийг нэр дэвшүүлэх хурлыг зохион байгуулав.</p> <p>Төрийн нарийн бичгийн даргын баталсан удирдамжийн дагуу энэ оны 06 дүгээр сарын 09-ны өдрөөс 12-ны өдрийг хүртэл Сэлэнгэ аймгийн нэгдсэн эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөлийн хамт олны төлөөллийг нэр дэвшүүлэх хурлыг зохион байгуулав.</p> <p>Төрийн нарийн бичгийн даргын албан бичгийн дагуу Цагдаагийн ерөнхий газраас зохион байгуулсан онц байдал зарласан үед ажиллах дадлага сургалтад оролцсон.</p>		

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 1. ТАЗ-ийн 7 хоног бүрийн цахим сургалтад оролцоно.	Оролцсон цахим сургалтын тоо	100%	Тухай бүр	Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан -БНСУ-ын Төрийн албаны сонгон шалгаруулалтын талаар -Төрийн албаны шинэтгэл ба цэгцрэх хөдөлгөөн -Байгууллага, хувь хүний санхүүгийн төлөвлөлт, удирдлага -Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгаа -Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хууль тогтоомжийг төрийн албан хаагч зөрчихөөс сэргийлэх нь -Төрийн жинхэнэ албан хаагчийг томилох үйл ажиллагаанд хяналт тавих нь -Төрийн албан хаагчийн ёс зүй, ёс зүй ба бодлого, үйл ажиллагаа -Дижитал ёс зүй Төрийн албан хаагчийн ёс зүй, гомдол мэдээллийг шийдвэрлэх нь, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн төрөл, тэтгэмж авах эрх үүсэх, хүсэлт хүлээн авах, шийдвэрлэх, Төрийн албан хаагчийн цалин, орон нутгийн нэмэгдэл зэрэг сургалтад цахимаар оролцсон.	01 12	
2.	Арга хэмжээ 2. Яамнаас зохион байгуулсан сургалтад оролцоно.	Оролцсон сургалтын тоо	100%	Тухай бүр	-Жендерийн мэдрэмжтэй төсөвлөлт -Хүмүүн байхын учир ёс суртахуунд оршмой /С.Нарангэрэл/ - "Эрүүл мэндийн салбарт үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх,	01 12	

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Салгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
					цаашид анхаарах асуудал /Эрүүгийн цагдаагийн албаны Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газар/ -Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, тохиолдсон үед авах арга хэмжээ -Процессын дахин инженерчлэл -Төрийн бүтээмжийн сэргэлт-Цахим эрүүл мэнд сургалтад оролцсон.		

ТАЙЛАН ГАРГАСАН:  
ТЗУГ-ын Хуулийн хэлтсийн  
Салбарын хууль эрх зүйн  
нэгдсэн зохицуулалт хариуцсан  
шинжээч  
(Албан тушаал)

.....  / Ш.Мөнгөнцэцэг /

2024.12.05

(Нэр, гарын үсэг)

(Огноо)